

БАТЛАВ



ЭРДМИЙН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А.ШИЙРЭВНЯМБА

ЭРДМИЙН СУРГУУЛИЙН
МАГИСТРЫН ЦАХИМ СУРГАЛТАД СУРАЛЦАГСДАД ЗОРИУЛСАН
“ЭРҮҮЛ МЭНДИЙН СУДАЛГААНД ТҮГЭЭМЭЛ АШИГЛАГДДАГ
ЗАГВАР БА СТАТИСТИК БОЛОВСРУУЛАЛТ”
СЭДЭВТ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Үндэслэл:

Эрдмийн сургуулийн магистрын цахим сургалтад суралцагсдын сургалтын хэрэгцээг тогтоон, дүн шинжилгээ хийх, сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн (PEO), хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO) хичээлийн суралцахуйн үр дүн (CLO) дүнг сайжруулах, БШУ-ны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/147 тоот тушаалын сургалт эрдэм шинжилгээ, сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажилтыг хангах, хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийн чанарыг үнэлэх, суралцагчдийн сэтгэл ханамжийг тодорхойлох, суралцагчийн ахиц дэвшил, мэргэжлийн хөтөлбөрийн чанарын үнэлгээг хийх хөтөлбөрийг эргэх холбоо тогтоон сайжруулахад оршино .

Зорилго

Магистрын цахим сургалтад суралцагсдад сургалтын чанар болон хүртээмжтэй байдлыг дээшлүүлэн эрүүл мэндийн судалгааны сонгодог загвар, үр дүнгийн статистик боловсруулалт, боломжит алдаанаас сэргийлэх тухай мэдлэг эзэмшүүлэн дэвшүүлсэн таамаглалд тохирох загварыг сонгон хэрэглэх ур чадварт суралцана.

Суралцагч, төгсөгч нартай уулзалт, ярилцлага хийж санал, хүсэлтийг хүлээн авах

Сургалтын хэрэгцээ

Эмнэлзүйн практикт ажиллаж буй магистрантуудын судалгааны төслийн хүрээнд бодитой хэрэгжүүлж болохуйц эмнэлзүйн тохиолдол, анагаах ухааны салбарын судалгааны загвар сонгох, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг ур чадварыг эзэмшүүлэн төлөвшүүлэх хэрэгцээ тулгарч байна.

Эмнэл зүйн тохиолдол, тохиолдлын цуврал, оношилгооны хүчин төгөлдөр байдал, эмнэл зүйн эх баримтын болон шинэ эмийн эмнэл зүйн судалгааг зохистойгоор хэрэгжүүлэх, дадал суулгахад уг сургалт зорих болно.

Сургалт нь аливаа асуудлын эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэн тогтоох тэдгээрийг хэмжих тоон судалгааны аргачлал, арга барилд суралцах ингэснээр судалгааны арга зүйн мэдлэг дадалд суралцах сурсан зүйлээ судалгааны төсөлдөө тусган хэрэгжүүлэх оновчтой сургалт болно.

Сэдвийн хамрах хүрээ:

Сургалтыг 2024 оны 4-р сарын 26 ны өдрийн 14:00-17:00 цагт Эрдмийн сургуулийн №09 тоотод танхим-цахим хосолсон байдлаар зохион байгуулна.

Сургалтад хамрагдах тухай мэдээллийг оюутнуудад цахим шуудангаар хүргэнэ.

Сургалтын хөтөлбөр:

№	Үйл ажиллагаа	Оролцогч
	Нээлт ЭС-ийн захирал А.Шийрэвнямба Зочин илтгэл АУ-ны доктор, дэд профессор Ж.Жамбалдорж Дурсгалын зураг авахуулах Сургалт Панелист АУ-ны доктор А.Номин	
1.	Эмнэл зүйн туршилт судалгааны загвар	Ц.Сарнай
2.	Судалгааны төсөл бичих үлгэрчилсэн загвар, түгээмэл гардаг алдаа	Ё.Мөнхзул
3.	Агшингийн загвар: Асуумжийн хүчин төгөлдөр, найдвартай байдал Цайны завсарлага	А.Анхбаяр
4.	Чанарын судалгааны арга, загвар	А.Номин
5.	Судалгааны төслийн статистик боловсруулалт	П.Одончимэг
6.	Бодлогын шинжилгээнд ашиглагддаг зарим загвар Суралцагсдын санал хүсэлтийг хүлээн авах, ярилцлага Асуулт, хариулт чөлөөт цаг	Ц.Сарнай ОУЦСТ ОУЦСТ
	Хаалт	

Хүрэх үр дүн:

1. Эрүүл мэндийн судалгаанд түгээмэл ашиглагддаг эмнэлзүйн туршилт судалгаа, агшингийн болон бодлогын шинжилгээний загварыг ямар үед хэрэглэдэг, үе шат, түүвэрлэлт, баталгаажилт, практик хэрэглээний талаарх мэдлэг
2. Судалгааны төсөл бичих загвар, формат
3. Эмчилгээний өмнө ба дараа, бүлгүүдийн үр дүнг харьцуулах, үр дүнгийн боловсруулт хийх, эх баримт бичгийн судалгаа төлөвлөх
4. Мэдрэг, өвөрмөц чанар, эерэг, сөрөг таамаглах утга тайлбарлах чадвар